

Аж төрөх  
ухаан

Г.Ловор

# ХЭНД ХЭН ҮЙЛЧИЛДЭГ ВЭ?



3-р  
ангийнханд  
зоруулав

**Г.Ловор**

**Хэнд хэн үйлчилдэг вэ?**

*Бага сургуулийн 3-р ангийн сурагчдад зориулав.*

Зураач

Л.Зулбадрах

Д.Сугархүү

Хянан тохиолдуулагч

О.Мөнхтуяа

Хянагч

Ж.Гэрэлмаа

Хэвлэлийн эх бэлтгэсэн

Н.Хөдөлмөр

Д.Хишигдэлгэр



Хэвлэн нийтлэлийг Интерпресс ХХК

2007 он

## ХЭНД ХЭН ҮЙЛЧИЛДЭГ ВЭ?

Нэг өдөр манайхыг зусландаа гараад байтал татварын байцаагч ирэв.

- Танайх зурагт, бас радиотой юм аа. Сарын татвараа төлнө өө! гээд хэдэн төгрөг нэхэж авав. Түүнийг явсны дараа бидний дунд ийм яриа өрнөлөө.

- Энэ хүн яагаад манай зурагт, радиогоос мөнгө авч байгаа юм бэ? гэж эхлээд охин маань асуув.

- Авалгүй яахав. Зурагт, радиог бид дэлгүүрээс худалдаж авсан ч гарч байгаа юм, ярьж байгаа зүйлийг тусгай хүн бэлдэж үйлчилдэг юм. Түүнийг нь бид үзэж, сонсдог гэсэнд,



- Тэгээд энэ хүн бэлддэг юм уу? гэж хүү лавлав.
- Энэ хүн тэр нэвтрүүлэг бэлддэг хүмүүсийн ажлын хөлсийг нэг ёсондоо авч байгаа юм.



- Олон хүн ажилладаг юм уу?

- Нэг хэсэг хүн сурвалжилга, нэвтрүүлэг хийх гэж хот, хөдөөгийн хүмүүстэй явж уулзана. Түүнийгээ бичнэ.

Яриа хөөрөөгийг нь соронзон хальсанд шингээж, бас дүрсийг нь буулгаж авна. Тэгээд ажлынхаа газар очиж, тусгай өрөөнөөс нөгөө бичиж бэлдсэн зүйлээ дэлгэц, долгионоор дамжуулна даа.

-Тэр яаж бидэнд сонсогдож, манай гэрийн зурагтанд ирж үзэгддэг юм бэ?



- Зурагтын нэвтрүүлэг нь гандангийн дэнж дээрх өндөр цамхгаас, радио нь Хонхорт байгаа станцаас усны долгио шиг агаараар тархдаг юм.



Дамжуулах газар болгонд техник хэрэгсэл байна. Техник хэрэгсэл бүрийг хүн ажиллуулна. Тэр хүмүүст цалин хэрэгтэй. Бас тоног хэрэгслийг худалдаж авах, шинэчлэхэд мөнгө хэрэгтэй.

Түүнд зарах мөнгийг нь энэ хүн цуглууж байгаа хэрэг гэж тайлбарлан хэлтэл,

- Энэ хүн мөнгөө аваачаад тэр хүмүүст хуваагаад өгчихнэ тийм ээ, ааваа? гэж хүү маань мэдэмхийрэв.

- Үгүй ээ! Хүү минь банкинд тушаана. Банк авсан мөнгийг нь хадгалдаг. Мөнгө хадгалсныхаа төлөө бас тодорхой хувийг нь авна.



- Банк өөрөө мөнгөтэй байж бас авдаг нь юу ч билээ? гэж ээж хажуугаас ярианд оролцлоо.

- Хувь хүн, компани, улсын үйлдвэрийн газруудын мөнгийг банк хүүтэй хадгална.

Авах гэсэн хэмжээгээр нь эргүүлэн өгч, бас хүнд, компанид зээлдүүлж өөрөө ашиг олно.

Тэгж байж, ажиллагсдаа цалинжуулна. Энэ бүхнийг засаг төр зохицуулж хяналт тавьж ажиллуулдаг юм аа. Тэгэхээр бид биедээ үйлчилж, мөнгө төлнө. Тэд ч энэ харилцааг хуулиар зохицуулж, ард олондоо үйлчилж байгаа хэрэг гэсэнд тэд толгой дохицгоож харагдав.

### **Бага сургуулийн 3-р ангийнханд зориулав.**



*Хүн өөрөө төдийгүй өрөөл олон түмний хүчээр ажиллах, амьдрах орчин ахуйгаа хамтран бүтээдэг.*



*Хүний гол хүнс талх, боов хамт олны хүч хөдөлмөрөөр буй болдог.*



*Байгууллага хүмүүсийн хоорондын харилцан үйлчилгээ бол нийтээр тохилог амьдрах, аж төрөх, улмаар нийгэм хөгжих боломж бүрдүүлдэг.*



*Зах зээлийн эдийн засгийн нөхцөлд бизнес эрхлэгч хэн ч бай, түүний үр ашгийг урьдчилан тооцоолж, сонголтоо зөв хийх нь чухал.*



Дэлхийн банктэй хамтран хэрэгжүүлж буй "Хөдөөгийн боловсролыг дэмжих (READ) төсөл"-ийн хүрээнд хэвлэв.  
Худалдахыг хориглоно.